



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар

А/697

Ховд

Зарим байгууллагуудын ажиллах
цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “ж”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Ховд аймгийн Онцгой комиссын дэргэдэх шуурхай штабын 2020 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолын хавсралтад дурдагдсан байгууллагуудаас бусад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл 09.00-14.00 цагийн хооронд ажиллах цагийн хуваарийг тогтоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

d/Zah-A/697/Bo